

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

Нэг. БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1965 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлигаар нийслэл Улаанбаатар хотын АДХ-ын харьяа Ажилчин, Найрамдал, Амгалан, Зүүнсэлбэ, Сүхбаатар, Хоршоолол, Чингэлтэй, Толгойт, Октябрь, Төмөр замын хороог татан буулгаж Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдлын районыг байгуулсан билээ.

Шинээр байгуулагдаж байгаа Сүхбаатарын район нь Улаанбаатар хотын төв хэсэгт байрлаж, зүүн талаараа Зүүн сэлбийн гол, баруун тал нь Гандангийн тойрог зам, Авто тээврийг шалган бүртгэх газрын баруун замаар Дунд гол хүртэл, урд тал нь дунд гол, хойт тал нь Халзангийн даваа Хандгайт, Улиастай зэрэг газрыг хамарсан 84000 метр квадрат нутаг дэвсгэрийг хамрах болсон байна. Тус район орон сууц гудамжны 44 хороо харъяалагдаж байжээ.

1965 оны 06 дугаар сарын 29-ний өдөр хуралдсан Сүхбаатарын районы АДХ-ын Анхдугаар чуулганаас Сүхбаатарын районы АДХГЗ-ны даргаар 38 дугаар тойргийн депутат Г.Цэдэвдоржийг баталж байжээ.

Сүхбаатарын районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1973 оны 10 дугаар сарын 4-ны өдрийн 72 дугаар тогтоолоор орон сууц гудамжны зарим хороод барилгын талбайн газарт орж айл өрхүүд нүүж байгаатай холбогдон Сүхбаатарын районы орон сууц гудамжны 3,29,33 дугаар хороодыг татан буулгасан байна. Мөн өрх цөөн, нэгдсэн байртай 32,33 дугаар хороодыг нийлүүлэн 32 дугаар хороо болгож, дэнжийн мянга орчмын 10 дугаар хороог хувааж 370 өрхтэйгээр 3 дугаар хороог шинээр мөн Дамбадаржаагийн чиглэлд хүн ам, айл өрх олширч байгаатай холбогдуулан 29 дугаар хороог байгуулсан байна.

1990 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр Сүхбаатарын районы АДХ-ын 16 дахь удаагийн сонгуулийн Анхдугаар чуулган болж Сүхбаатарын районы Ардын хуралд доорх комиссуудыг байгуулсан байна. Үүнд:

1. Депутатын асуудал эрхэлсэн комисс
2. Нийгэм-эдийн засгийн асуудал эрхэлсэн комисс
3. Хүн амын үйлчилгээний байнгын комисс
4. Хот тохижилт, байгаль орчныг хамгаалах асуудал эрхэлсэн байнгын комисс
5. Эрх зүйн асуудал эрхэлсэн байнгын комисс

Монгол Улсын Их хурлын 1992 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын Ажилчин, Найрамдал, Сүхбаатар, Октябрь, Налайх, Багануур, Партизан, Гачуурт, Туул, Багахангай хороог татан буулгаж, нийслэл Улаанбаатар хотод шинээр Хан-Уул, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан, Налайх, Туул, Багануур, Багахангай, Жаргалант, Гачуурт дүүргүүдийг байгуулсан байна.

Улаанбаатар хотын АДХГЗ-ны 1992 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн чуулганаар МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хороо, дүүрэгт хөдөлмөрчдийн төлөөлөгчдийн хурал болон хороо дүүргийн Засаг дарга нарыг сонгон томилууж, шинэ бүтэц зохион байгуулалтаар ажиллах болсон байна.

Засаг даргын Тамгын газарт:

Удирдлага- 3
Засаг захиргааны хэлтэс- 15
Санхүүгийн хэлтэс- 8
Хүн амын бодлого, хөдөлмөрийн хэлтэс- 18
Цэрэг иргэний хамгаалалтын хэлтэс- 5
Хянан байцаах хэлтэс- 5
Статистик мэдээлэлийн тасаг- 4

Бүгд 67 орон тоотойгоор ажиллах болсон байна.

Орон сууцны 16 хороотой хороодын Засаг даргын дэргэд тус бүр нэг зохион байгуулагч ажиллах болжээ.

Шинэ бүтэц зохион байгуулалтаар ажиллах болсонтой холбогдон Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж, бүх ажилтан албан хаагчтай хөдөлмөрийн гэрээг шинээр байгуулж, ажил үүргийн хуваарийг шинэчлэн боловсруулсан байна.

Төр засгаас нийгэм эдийн засгийн байгууллыг зах зээлийн харилцаанд зохицуулан шилжүүлэх эхлэлийг тавьснаар өмчийн олон хэлбэр үүсч улс орны эдийн засгийн хөгжилд шинэ төлөв нээгдсэн.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 1994 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 207 дугаар захирамжаар дүүргийн Засаг даргын дэргэд биеийн тамир спорт сургалтын төв байгуулж ажиллуулжээ. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 1994 оны 11 дүгээр сарын 16-ний өдрийн 306 дугаар захирамжаар нийгэм хангамжийн хэлтсийг тус дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс болгон зохион байгуулсан байна.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 1995 оны 04 дүгээр сарын 1-ны өдрийн 80 дугаар захирамжаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хэлтэст санхүүгийн хяналт шалгалтын тасаг байгуулан ажиллуулах болжээ. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 1996 оны 02 дугаар сарын 8-ны өдрийн 43 дугаар захирамжаар дүүргийн Тамгын газрын дотоод журмыг баталсан байна.

Монгол Улсын Их Хурлын 1996 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор нийслэл, дүүргүүдийн нутаг дэвсгэрийн хилийн цэс-ийг шинэчлэн тогтоосон байна. Уг тогтоолоор Сүхбаатар дүүргийн хилийн цэс нь Ганц худгийн толгой, Сэлбийн рашаан, Сэлбэ гол хүрч голоор уруудан Тээвэрчдийн гудамжны гүүр хүрч баруун тийш эргэн Тээвэрчдийн гудмаар явж, Их тойруугаар хойш эргэн баруун дөрван зам хүрч зүүн тийш эргэн Энхтайваны өргөн чөлөөгөөр явж Сүхбаатарын гудамж хүрч хойшоо эргэн Их тойруугаар баруун тийш эргэн Дэнжийн мянгын урд талын засмалаар Сэлбийн гүүр хүрч, Сэлбийн голоор өгсөн Халзангийн даваа, Мухарын даваа, Цохист уул, 2033,5 тоот, Духын даваа, Гүнтийн

хадан уул, 2042,7 тоот, Сэрвэн уулыг хярлан уруудан 1891,0, 1713,2,1582,3 тоот өндөрлөгөөр хязгаарлагдах болсон байна.

1997 онд төрийн захиргааны бүх шатны байгууллагад бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж Засгийн газрын 1996 оны 263 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын Б/06 дугаар захирамжийг үндэслэн дүүргийн Тамгын газрын бүтэц өөрчлөгдөж 3 хэлтэстэй зохион байгуулагдан ажиллах болсон байна.

- ✓ Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
- ✓ Төлөвлөлт санхүү эдийн засгийн хэлтэс
- ✓ Орон нутгийн үйлчилгээний хэлтэс эдгээр болно.

Дүүргийн Засаг даргын Тамгын газраас Тамгын газрын дэргэдэх хэлтэс алба, тасгуудын ажлын уялдаа холбоог дээшлүүлэх, дотоод хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор дотоод журам, дүрмийг нь шинэчлэн боловсруулж мөрдүүлэн ажиллуулж ирсэн ба улирал сард тайланг сонсож, дотоод ажлын үйл ажиллагаанд нь хяналт тавих, шалгах, ажлаа төлөвлөх зэрэгт нь санал, зөвлөгөө, үүрэг өгч ажиллаж иржээ.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 1997 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 56 тоот захирамжаар Тамгын газрын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдон хэлтсүүдийн дүрмийг шинэчлэн баталсан байна.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 1997 оны 8 дугаар сарын 11-ны өдрийн 238 дугаар захирамжаар дүүргийн мал эмнэлэг үржлийн албыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллах төрийн өмч бүхий улсын үйлдвэрийн газар болгон зохион байгуулжээ.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 1997 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 306 дугаар захирамжаар дүүргийн Засаг даргын дэргэд Статистикийн тасгийг байгуулсан байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1998 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 18 дугаар тогтоолоор дүүрэг хөгжүүлэх санг байгуулж, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилсон байна.

Дүүргийн Засаг даргын 1997 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 353 дугаар захирамжаар Засаг даргын Тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтсийн бүрэлдэхүүнд дүүргийн Цэрэг иргэний хамгаалалтын штабыг байгуулсан байна.

Дүүргийн ИТХ-ын 2000 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 22 дугаар тогтоолоор дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйл хэрэгт идэвх зүтгэл, үр бүтээл гарган ажилласан болон онцгой амжилт гавьяа байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийг алдаршуулахад зориулан дүүргийн ойг тохиолдуулан дүүргийн шагнал “Хүндэт тэмдэг”-ийг бий болгосон.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2000 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 99 дүгээр захирамжаар дүүргийн Засаг даргын дэргэд газрын харилцааны албыг байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2000 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн 423 дугаар захирамжаар дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоосон байна. Үүнд:

1. Дүүргийн удирдлагыг Засаг даргаас гадна Засаг даргын орлогч нэг

2. Тамгын газар нь: - Тамгын газрын дарга

- ✓ Төрийн захиргаа удирдлагын хэлтэс иргэний бүртгэлийн тасаг
- ✓ Төлөвлөлт. Санхүү эдийн засгийн хэлтэс
- ✓ Нийгмийн хөгжлийн хэлтэс
- ✓ Тохижилт, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс
- ✓ Цэрэг иргэний хамгаалалтын штаб

Дүүргийн Засаг даргын дэргэд хэлтсүүдийг ажиллуулах болсон байна. Үүнд:

1. Татварын хэлтэс
2. Нийгмийн даатгалын хэлтэс
3. Цагдаагийн хэлтэс
4. Статистикийн хэлтэс
5. Санхүүгийн хяналт шалгалтын тасаг
6. Газрын харилцааны алба
7. Эрүүл мэндийн хяналтын алба
8. Хөдөлмөрийн алба
9. Эрүүл мэндийн нэгдэл
10. Спорт сургалтын төв
11. Халамжийн төв
12. Сургалт үйлдвэрлэлийн төв
13. Тохижилт үйлчилгээний компани

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргад Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг давхар хариуцуулан болжээ.

Нийслэлийн засаг даргын 423 дугаар захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2001 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 03 дугаар захирамжаар Тамгын газрын төрийн захиргааны удирдлагын, орон нутгийн үйлчилгээний, төлөвлөлт санхүү эдийн засгийн хэлтсүүд, цэрэг иргэний хамгаалалтын штабыг татан буулгаж Тамгын газарт дараах нэр бүхий хэлтсүүдийг байгуулсан байна. Үүнд:

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс / Иргэний бүртгэлийн ба Аж ахуйн тасаг /
2. Санхүү эдийн засгийн хэлтэс
3. Цагдаагийн хэлтэс
4. Статистикийн алба
5. Санхүүгийн хяналт шалгалтын тасаг
6. Газрын харилцааны газар
7. Эрүүл мэндийн хяналтын газар
8. Хөдөлмөр эрхлэлтийн алба
9. Эрүүл мэндийн нэгдэл

10. Спорт сургалтын төв
11. Халамжийн төв
12. Сүх жанжин УҮГ
13. Соёлын төв
14. Тохижилт үйлчилгээний компани эдгээр болно.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2001 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 35 дугаар захирамжаар дүүргийн Засаг даргын дэргэдэх хөдөлмөр зохицуулалтын албыг татан буулгаж Засаг даргын дэргэдэх хөдөлмөрийн албыг байгуулсан байна.

2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 05 дугаар тогтоолоор дүүргийн бэлэгдлийг дүүргийн Сүлд тэмдэг, Тугийн загвар зураглал, тайлбарыг болон хүндэтгэлийн ажиллагааны журмыг баталсан байна.

Дүүргийн ИТХТ-ийн 2003 үны 10 дугаар тогтоолоор дүүргийн шагналын төрөл, түүнийг олгох журмыг шинэчилжээ. Үүнд:

1. Дүүргийн хүндэт “ Эрхэм дээд “ одон
2. Дүүргийн ИТХ-ын “ Хүндэт өргөмжлөл”
3. Дүүргийн “ Хүндэт тэмдэг “
4. ИТХ. Засаг дарга, Тамгын газрын баярын бичиг, талархал, дурсамж байхаар баталсан байна.

Засгийн газрын 2003 оны 07 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн хяналтын албыг татан буулгаж нийслэлийн Мэргэжлийн хяналтын хэлтэст шилжүүлэв.

2004 онд Статистикийн хуульд өөрчлөлт оруулсаны улмаас дүүргийн Засаг даргын дэргэдэх Статистикийн тасгийн үйл ажиллагааг өргөтгөн Статистикийн хэлтэс болгон өөрчилжээ.

2005 онд дүүрэг байгуулагдсаны 40 жилийн ойгоор дүүргийн шагналын төрөл, журмыг шинэчилжээ. Үүнд:

- Дүүргийн “ Хүндэт тэмдэг”
- “Хөдөлмөрийн алдар” медаль
- Засаг даргын “Өргөмжлөл”
- Тамгын газрын “ Баярын бичиг “
- ”Шилдэг хүүхэд“ медаль гэсэн 5 төрөл болгож шагналын журмыг баталжээ.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2005 оны 33 дугаар захирамжаар Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурьдсанаар баталжээ. Үүнд:

1. Төрийн захиргааны хэлтэс /иргэний бүртгэлийн тасагтай /
2. Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс
3. Нийгмийн хөгжлийн хэлтэс
4. Үйлдвэрлэл, тохижилт, үйлчилгээний хэлтэс
5. Цэргийн штаб

6. Аж ахуйн тасаг

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 68 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 12 дугаар захирамжийг үндэслэн СБД-ийн Засаг даргын 2009 оны 12 дугаар захирамжаар тус дүүргийн Тамгын газрын бүтэц орон тоог дараах байдлаар шинэчлэн баталсан байна. Үүнд:

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс/ бүртгэл мэдээллийн ба аж ахуйн тасагтай/
2. Санхүү, төрийн сангийн хэлтэс
3. Нийгмийн хэлтэс
4. Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс
5. Цэргийн штаб

Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар нь 2011 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 85 дугаар захирамжаар Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2008 оны 68 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 8 дугаар захирамжийг тус тус үндэслэн Засаг даргын Тамгын газрын бүтэцийг дор дурьдсанаар баталсан байна. Үүнд:

1. Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс / Бүртгэл мэдээллийн тасаг, аж ахуйн тасагтай /
2. Санхүү, төрийн сангийн хэлтэс
3. Нийгмийн хэлтэс
4. Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс
5. Цэргийн штаб

Хоёр. ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТҮҮХ

Тус газрын архивын баримтанд хөмрөг үүсгэгчийн үйл ажиллагаа эхэлснээс хойш өнөөг хүртэл 6 удаа эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажил хийгдсэн байна. Үүнд:

1. 1981 онд УТТА-ын тооцооны группын архивч, сэлбэн засагчдаар
 - 1963-1980 оны байнга хадаглах 821 хн-тэй данс
2. 1993 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын архивын тооцооны группын архивч, сэлбэн засагчаар
 - 1981-1990 оны байнга хадаглах 220 хн-тэй данс
3. 1995 онд УАХЭГ-ын 3 архивчаар
 - 1990-1994 оны 48 хн-тэй данс
4. 2000 онд Нийслэлийн архивын албаны архивч Цэцэгмаагаар
 - 1981-2000 оны 203 хн-тэй данс
5. 2001 онд тамгын газрын архивын эрхлэгч Байгалмаагаар

- 1996-2000 оны 16 хн-тэй данс
- 6. 2009 онд Тамгын газрын архив, бичиг хэргийн эрхлэгч Батсайханаар
 - 2000-2008 оны 85 хн-тэй данс тус тус хийсэн байна.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын архивын баримтанд 2013 оны 03 дугаар сарын 28-наас Нийслэлийн архивын гэрээт ажилтан Ч.Цэцэгмаа тус байгууллагын хүсэлтийн дагуу эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн боловч мэргэжилтнүүд заавар зөвлөлгөөгүй улмаас дахин ажил хийв.2008 оноос 2012 оны Засаг даргын захирамж, тушаал, харилцсан бичгүүдийг А,Б-р ялгаж, бүх данс бүртгэл дахин засагдаж, ХН-үүдийг үдэж хавтаслах, хуудас дугаарлав.

Байнга хадгалах баримтанд Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаал, хурлын тэмдэглэл, төлөвлөгөө тайлан, төсөв, тайлан тэнцэл, мөрийн хөтөлбөр, үр дүнгийн гэрээ, гадаад харилцааны материал, тендерт шалгарсан материал зэрэг орсон болно. Түр хадгалах баримтанд гаднаас ирсэн гадагш явуулсан бичиг, касс харилцах меморалын баримт, тендерт шалгараагүй баримт, ААН байгууллагуудын санхүүгийн тайлан орсон болно.70 жилд орон сууцны өргөдөл хувийн хэрэг, асран хамгаалагч харгалзан дэмжигчийн холбогдолтой баримт, цалингийн карт, цалингийн цэс орсон болно.Устгах бичгийн жагсаалтанд хадгалах хугацаа дууссан эрдэм шинжилгээ практикийн ач холбогдолгүй 1985-2010 оны 845 хн ялган бүртгэсэн болно. Захиргааны зөвлөлийн хурлын материал, жилийн эцсийн тайлан тэнцэл зэрэг баримт дутуу бөгөөд удаа дараалан нэхсэн боловч байхгүй мэдэхгүй хэмээн өгөөгүй болно. ЭШТБ-ын ажил хийгдэж байх явцад архивын мэргэжилтнүүд ажлын заавар зөвлөлгөө өгөөгүйн улмаас ажил дахин хийгдэж хугацаа удааширлаа. Мөн складанд хадгалагдаж байсан санхүүгийн голдуу баримт урд нь ер ЭШТБ хийгдэж байгаагүй байсан бөгөөд архивын эрхлэгч Мөнхзаяа, гэрээт ажилтан Билгүүн нараар 1986-1990 оны баримтыг байнга, түр, устгахаар ялгуулж 70 жил хадгалах 1986-1990 оны 48 хадгаламжийн нэгжээс цалингийн карт, цалингийн тооцооны хүснэгт, шагналын олгохтой холбоотой баримт, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны хуудсыг түүвэрлэн авч, 1986-1990 оны санхүүгийнхугацаа дуусч задлагдсан баримтаас харилцах, орлого,зарлагын баримтыг устгах хэргийн жагсаалтанд оруулав

ЭШТБ-ын ажлын үр дүнд:

- 2001-2009 оны 153 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 2010-2012 оны 227 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах үргэлжлэх данс

- 2002-2012 оны 1955 хадгаламжийн нэгж бүхий түрийн бүртгэл,
- 1979-2012 оны 95 хадгаламжийн нэгжийн 70 жилийн бүртгэл,
- 2005-2011 оны 13CD бүхий дүрс бичлэгийн бүртгэл,
- 2005-2010 оны 7CD бүхий гэрэл зургийн баримтын бүртгэл
- 1985-2010 оны эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 17 нэр төрлийн 835 хадгаламжийн нэгжийг устгах устгах хэргийн актыг тус тус үйлдэв.

Дээрх данс, бүртгэл, актыг Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх БНШК-ийн 2014 оны 03дугаар сарын 10-ны 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ийн хурлаар оруулахаар шийдвэрлэв.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Товчлол	Тайлал
1	2	3
А		
1	АДХГЗ	Ардын Депутатын Хурлын Гүйцэтгэх Захиргаа
2	ААН	Аж Ахуй Нэгж
3	АИХ	Ардын Их Хурал
4	АДХ	Ардын Депутатын Хурал
5	ААХХ	Архив Албан Хэрэг Хөтлөлт
Б		
6	БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
7	ББНШАЗК	Баримт Бичиг Нягтлан Шалгах Арга Зүйн Комисс
Д		
8	Д	Данс
9	Д/д	Дэс Дугаар
З		
10	ЗГ	Засгийн Газар
11	ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
Е		
12	ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
И		
13	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
М		
14	МУ	Монгол Улс
15	МУИС	Монгол Улсын Их Сургууль
16	МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
С		
17	СБД ЗДТГ	Сүхбаатар Дүүргийн Засаг Даргын Тамгын Газар
18	СБД	Сүхбаатар Дүүрэг
У		
19	УИХ	Улсын Их Хурал
20	УАХЭГ	Улсын Архивын Хэрэг Эрхлэх Газар
21	УТТА	Улсын Түүхийн Төв Архив
22	УБ	Улаанбаатар
Х		
23	ХАА	Хөдөө Аж Ахуй
24	Х	Хөмрөг
25	ХН	Хадгаламжийн Нэгж
Э		
26	ЭШТБ	Эрдэм Шинжилгээ Техник Боловсруулалт